



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Үүнээс хойш банкны засаглалыг сайжруулах, хараат бус, бие даасан байдлыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх зорилгоор 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр тус хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

“Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлэх хуулийн төслийн жагсаалтад “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд Монгол Улсын Их Хурлаас байгуулсан Хянан шалгах түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 26 дугаар тогтоол гарч, “... Хөгжлийн банкийг цогцоор нь иж бүрэн өөрчлөн зохион байгуулж, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, ... хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, ... холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх” үүргийг Засгийн газарт өгсөн болно.

Дээр дурдсан Улсын Их Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой уялдуулан эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор шийдвэрлэсэн тул Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

1.2. Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан. Тус хуулиар Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой байхаар хуульчилсан. Үүний хүрээнд Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргах нийт санхүүжилтийн дүнгийн 60-аас доошгүй хувийг экспортыг дэмжсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулахаар нарийвчлан зохицуулсан.

Гэвч тус банкны өнгөрсөн хугацааны санхүүгийн үзүүлэлт, зээлийн чанар зэргээс үзэхэд, хуулиар тодорхойлсон үйл ажиллагааны чиглэлийн дагуу хангалттай ажиллахгүй байна.

Тухайлбал, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг хэрэгжүүлэх явцад дараах хүндрэлтэй асуудлууд үүсэж байна:

1/Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу тус банк нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх бөгөөд зээл, санхүүжилт олгох шийдвэрийг бие даан гаргахаар зохицуулсан.

✓ Гэтэл өнөөдрийг хүртэл хугацаанд тус банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн дийлэнх нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөр зэрэгт хамаарахгүй буюу арилжааны банкнаас санхүүжүүлэх бүрэн боломжтой төсөл хөтөлбөрт санхүүжилт олгосон байна. Ингэснээр арилжааны банкуудын олгосон чанаргүй зээлийг дахин санхүүжүүлэх, эдийн засгийн үр ашиггүй төсөл, хөтөлбөрт санхүүжилт олгосон зэрэг банкны санхүүгийн үзүүлэлт хүндрэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн;

2/Төлөөлөн удирдах зөвлөл Банкны дунд, урт хугацааны стратегийг оновчтой тодорхойлж, энэ хүрээнд банкны бодлого, журмыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үндсэн чиг үүрэгтэй байдаг. Гэтэл хуульд тус банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах эрх хэмжээ, түүний хязгаарыг тодорхой зааглаж тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож зээл, санхүүжилт олгох, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах шийдвэрийг гаргаж ирсэн байна.

✓ Ингэснээр банкны өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хангаж ажиллах үүрэгтэй гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, хариуцлага суларч, цаашлаад банкнаас олгох төсөл, хөтөлбөрийн санхүүжилт сунжрах, цаг хугацаа алдах, төсөл, хөтөлбөрийг эрсдэлд оруулж, банкны үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

3/Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Экспорт, импортын санхүүжилт хийх төсөл, хөтөлбөр нь техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн байх заасан шаардлагыг хангасан байх” гэж тусгасан нь банк гадаад худалдааны санхүүжилтийн төлбөр тооцоотой холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, өргөжүүлэх, харилцагчдад санал болгоход хүндрэл үүсгэж байна.

Мөн Монгол Улсын Хөгжлийн банкнаас гадаад худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авах харилцагчдад тавигдах шаардлага, бүрдүүлэх материалыг илүү уян хатан болгох, гадаад худалдааны санхүүжилтийг худалдааны гэрээ, хэлцэлд үндэслэн олон улсын стандарт болон олон улсын банкуудын нэгдсэн журмаар зохицуулагддаг үйл ажиллагаатай уялдуулж өөрчлөх шаардлагатай байна.

Олон улсын жишигт тухайн улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортлох, гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор экспортын баталгааны сан, экспортын зээлийн агентлаг болон эксим банкныг байгуулан ажиллуулдаг бөгөөд ихэвчлэн төрийн оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулан хэрэгжүүлж байна.

Иймд дээрх үндэслэл шаардлагын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааны үндсэн чиглэл, чиг үүргийг өөрчилж, ЭКСИМ банкны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслөөр Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг экспортын санхүүжилтийг олгоход чиглүүлэх, төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхдээ банкны өөрийн хөрөнгийн тавин хувиас дээш дүнтэй тэнцэх хэмжээний төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, ингэхдээ экспортын орлогыг дэмжсэн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, түүнчлэн банкны засаглал, үйл ажиллагааг нарийвчлан зааглаж, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой зохицуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

Монгол Улсын Хөгжлийн банкны бүтээгдэхүүн үйлчилгээг экспортын банкны үндсэн чиг үүрэгт нийцүүлэх бөгөөд энэ хүрээнд тус банкнаас үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээний зааг, хязгаарыг тогтооно.

Хууль зүйн болон практик шаардлагад үндэслэн дараах агуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулна:

2.1.Хөгжлийн банкны үйл ажиллагааг тодорхой болгоно.

Монгол Улсын Хөгжлийн банкны эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн 5 дугаар зүйлд Хөгжлийн банк нь экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд шинээр нэвтрүүлэн төрөлжүүлэх, үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх асуудлыг нарийвчлан тодорхойлно.

2.2.Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн шалгуур, амжилттай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Хөгжлийн банкнаас экспортын санхүүжилт олгох, баталгаа, батлан даалт гаргах, даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлах зохицуулалтыг тусгана.

Мөн хууль тогтоомжид заасан хязгаарлалттай нийцүүлэн дангаар болон бусад этгээдтэй хамтран гуравдагч этгээдэд экспортын худалдааны санхүүжилтийн үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд тавигдах шаардлагыг бүтээгдэхүүн бүрээр хуульд тодорхой зааж, улмаар тухайн шаардлагуудыг хангаж байгаа эсэхэд Хөгжлийн банк мэргэжлийн үүднээс дүгнэлт хийж, санхүүжилт олгох эсэх эцсийн шийдвэрийг гаргадаг байхаар зохицуулна.

Хөгжлийн банк тогтвортой хөгжлийн санхүүжилтийн үзэл баримтлалыг байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогоор дамжуулан нэвтрүүлэх зохицуулалтыг тус тус тусгана.

2.3.Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан этгээдийн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.

Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан этгээд үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, барьцаа хөрөнгийн талаарх мэдээ, баримтуудыг Хөгжлийн банканд тогтмол гаргаж өгч, үнэн бодит мэдээллээр хангадаг байх зохицуулалтыг нэмнэ.

Хөгжлийн банкны санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулсан нь тогтоогдсон тохиолдолд хариуцлага хүлээдэг байх зохицуулалт тусгана.

2.4.Хөгжлийн банкны үйл ажиллагаа, засаглалын тогтвортой байдал, шийдвэр гаргалтын эрх хэмжээг зөв хуваарилах, санхүүжилтийг ил тод болгоно

Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт тавигдах хуульд заасан шалгууруудыг хангаж байгаа талаар болон шалгуур хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргалтын хуваарилалтыг тодорхой болгон, гүйцэтгэх удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэхээр тусгана.

Түүнчлэн, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, түүний хэрэгжилтийн явц, судлагдаж байгаа төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгож, банканд хийсэн хяналт, шалгалтын тайлангийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хяналт, шалгалт хийдэг байх тогтолцоог бүрдүүлэх зохицуулалтыг тус тус тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар экспортыг дэмжих төслүүдийг шуурхай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх бөгөөд энэ нь цаашид эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах, иргэдийг ажлын байраар хангах, тогтмол орлогын эх үүсвэртэй болгоход чухал нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн уг хуулийн төсөл батлагдсанаар банк тогтвортой, үр ашигтай ажиллах, үйл ажиллагааны эрсдэл буурах, зээл олгох үйл ажиллагааны шуурхай байдал хангагдах, банкны үйл ажиллагааны хүрээ өргөжих, компанийн засаглал бэхжих бөгөөд банкны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо боловсронгуй болсноор олон нийтийн банканд итгэх итгэл нэмэгдэж, банкны нэр хүнд, зээлжих зэрэглэл өсөх, хуулийн хориглосон заалтуудаар хязгаарлалт, цар хүрээг тодорхой болгоно.

Мөн банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалын бодлого, стратеги төлөвлөлт, эрсдэлийн удирдлага, бизнес төлөвлөгөө, санхүүгийн болон бусад үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах үйл явц бэхжиж, нөлөөллөөс ангид, мэргэжлийн, шуурхай болох, зээлдэгчийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө, болзошгүй эрсдэлийг удирдах, гадаадын банк, санхүүгийн

байгууллагаас тогтвортой, ногоон ангилалд багтах хямд эх үүсвэр татан төвлөрүүлэхэд нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---